




1. Дараах графикт зарим аймгуудын номын санд байгаа хүүхдийн номын тоог харуулжээ. Аль нь зөв дүгнэлт вэ?



- A. Сэлэнгэ аймагт хамгийн олон буюу нийт номын 50 хувь орчим нь байна.
 B. Төв болон Дорнод аймгийн номын нийлбэр Архангай аймгийнхаас их байна.
 C. Дорнод аймгийн номын тоо Сэлэнгэ аймгийнхаас 2 дахин бага байна.
 D. Дундговь болон Төв аймгийн номын нийлбэр Завхан аймгийнхтай тэнцүү байна.
2. Объектын тухай мэдээллийг цуглуулж, түүнд тулгуурлан объектын шинж чанарыг тусган дүрсэлснийг загвар гэнэ. Дараах зурагт өгөгдсөн загвар болон түүний бодит объектын шинж чанаруудыг утгатай нь харгалзуулна уу.



1. Объектын орчин
 2. Загварын ангилал
 3. Загварыг үүсгэсэн орчин
 4. Объектын нэр
- A. MS Paint программ
 B. Мэдээллэн загвар
 C. Анги танхим
 D. Сандал
- A. 1с, 2b, 3а, 4d B. 1а, 2d, 3с, 4b C. 1с, 2d, 3а, 4b D. 1а, 2с, 3b, 4d
3. Дараах зурагт дугуй дүрсүүдээр ямар үзэгдлүүдийг загварчилсан байгааг сонгоно уу.




- A. ус, мөс, тос B. хатуу, шингэн, хий C. давс, хүчил, ус D. уурших, хайлах, хөөрөх

4. Сурагч сургуулийнхаа цахим хуудсанд нийтлэл бичихээр болов. Компьютерын төхөөрөмжүүдийг цахим нийтлэл боловсруулах үе шаттай уялдуулан, үүрэгтэй нь зөв харгалзуулна уу.

Төхөөрөмж	Үүрэг
	A. Нийтлэлийн бичвэрт алдаа байгаа эсэхийг шалгах, зургууд зөв байрласан эсэхийг хянах
	B. Нийтлэлд өгүүлбэр, тоо баримтыг дараалалтайгаар бичиж оруулах
	C. Нийтлэл бичихэд ашиглаж буй программын цэсээс команд сонгож, зураг болон бичвэрийн байрлалыг өөрчлөх
	D. Нийтлэлд оруулах бичлэгийн яриа тод сонсогдож байгаа эсэхийг шалгах
	E. Нийтлэлд оруулах бүх мэдээллийг нэгтгэн боловсруулж, файл болгон хадгалах

- A. 1e, 2d, 3c, 4a, 5b
B. 1d, 2a, 3e, 4c, 5b
C. 1a, 2d, 3e, 4b, 5c
D. 1e, 2d, 3a, 4b, 5c

5. Сурагч 15 хуудастай баримт бичиг дээр ажиллаж байв. Компьютерын дэлгэц дээр баримт бичгийн эхний хэсэг харагдаж байгаа ба дараагийн хэсгийн мэдээллийг харахын тулд хулганыг хэрхэн зөв ашиглах вэ?



- A. Баримт бичгийг идэвхжүүлэхийн тулд хулганын зүүн товчийг нэг удаа дарна.
B. Нэмэлт команд харахын тулд хулганын баруун товчийг нэг удаа дарна.
C. Баримт бичгийн дараагийн хэсгийг сонгохын тулд хулганын зүүн товчийг дарж хөдөлгөнө.
D. Баримт бичгийн агуулгыг гүйлгэхийн тулд хулганын голын дугуйг урагш болон хойш эргүүлнэ.

6. Компьютерын гарын товчлууруудыг ашиглаад гарсан үр дүнг зөв харгалзуулна уу.

Товчлуур	Үр дүн
1. 	A. Компьютерын дэлгэцийг түгжих
2. 	B. Мэдээллийн технологийн хичээл
3. 	C. Компьютер
4. 	D. Үйлдэл буцаах

- A. 1d, 2c, 3a, 4b
B. 1c, 2a, 3b, 4d
C. 1a, 2d, 3c, 4b
D. 1c, 2d, 3b, 4a


7. Компьютерын эрүүл ахуйн дүрэмд нийцэж байвал үнэн (Y), нийцэхгүй байвал худал (X) үсгээр тэмдэглэж зөв хариултыг сонгоно уу.

- Гар, хулгана зэрэг тоног төхөөрөмжийг салгаж зөөхгүй байх, цахилгаан кабель утаснуудтай болгоомжтой харьцах
- Өөрт тохиромжтой сандал дээр нуруу цэх, хөлөө шалан дээр гишгэн, чөлөөтэй суух
- Компьютер унтраахдаа тэжээлээс шууд салгаж болно.
- Дэлгэц хэрэглэгч хоёрын хооронд 50-70 см, харааны түвшин дэлгэцийн дээр хэсэгт төвлөрч байх
- Компьютер дээр удаан хугацаагаар ажиллах үед нүдээ амрах шаардлагагүй.


- A. 1-Y, 2-X, 3-Y, 4-Y, 5-X
B. 1-Y, 2-Y, 3-X, 4-Y, 5-X
C. 1-X, 2-Y, 3-Y, 4-X, 5-Y
D. 1-Y, 2-X, 3-Y, 4-X, 5-X

8. Дараах зурагт бичвэр мэдээлэл боловсруулах программын график интерфэйсийг харуулжээ. Бичвэр мэдээлэлтэй ажиллахдаа дараах үйлдлүүдийг хийхэд тохирох график интерфэйсийн элементүүдийг зөв хослуулсныг сонгоно уу.

- Үйлдэл-1: Бичвэр мэдээлэл нийт хэдэн хуудсанд бичигдсэнийг шалгах
- Үйлдэл-2: Бичвэр мэдээллийн үсгийн хэмжээг 12 pt болгон тохируулах




- A. Үйлдэл-1: Цэсийн мөр
Үйлдэл-2: Хуваарьт шугам
- B. Үйлдэл-1: Ажлын талбар
Үйлдэл-2: Төлөвийн мөр
- C. Үйлдэл-1: Төлөвийн мөр
Үйлдэл-2: Цэсийн мөр
- D. Үйлдэл-1: Ажлын мөр
Үйлдэл-2: Гарчгийн мөр
9. Сурагч компьютер дээр Ч.Лодойдамбын “Шаргачин” өгүүллэгийг шивж оруулахаар болов. Эхний өгүүлбэрийг дуусгаад цэг (.) тавьсан бол дараагийн өгүүлбэрийг шивэхдээ ямар үйлдэл хийх шаардлагатай вэ?
- A. Shift товчлуур дараад бичнэ.
- B. Alt товчлуур сул зай авна.
- C. Backspace товчлуур дарж сул зай авна.
- D. Space товчлуур дарж сул зай авна.
10. Компьютерын гарын үндсэн байрлалаар зөв бичигдсэн үгийг сонгоно уу.
- A. дараа
- B. бороо
- C. хороо
- D. сэрээ
11. Компьютерын гарын хурууны зөв байрлалаар ядам болон долоовор хуруунуудыг ашиглан бичихэд бүтэх зөв үгийг сонгоно уу.



- A. бал
- B. гар
- C. луу
- D. цаг

12. Дараах өгүүлбэрийг компьютерын гарын хурууны зөв байрлалаар бичсэн ч сурагч алдаатай бичжээ. Түүний бичсэн бичвэрийн алдааг засахад дарагдах хурууны байрлалын зөв дарааллыг сонгоно уу. *Өгүүлбэрийг урдаас нь эхлэн засварлана.*

Өгүүлбэр: **Бархасбадь грагийндотор мнга гаруй дэлхийг багтааж блно.**




- A. 4 → 5 → 1 → 7
B. 5 → 4 → 1 → 7
C. 4 → 5 → 7 → 1
D. 3 → 4 → 5 → 6

13. Мөр зэрэгцүүлэх командуудыг үр дүнтэй нь зөв харгалзуулна уу.

Команд	Үр дүн
1. 	A. Дэлхийн хамгийн жижиг шувуу харандааны үзүүр дээр сууж чадна.
2. 	B. Дэлхийн хамгийн жижиг шувуу харандааны үзүүр дээр сууж чадна.
3. 	C. Дэлхийн хамгийн жижиг шувуу харандааны үзүүр дээр сууж чадна.
4. 	D. Дэлхийн хамгийн жижиг шувуу харандааны үзүүр дээр сууж чадна.


- A. 1d, 2c, 3b, 4a
B. 1d, 2a, 3c, 4b
C. 1c, 2a, 3d, 4b
D. 1c, 2d, 3b, 4a

14. Дараах хэлбэржүүлэлтийн дагуу зөв бичигдсэн бичвэрийг сонгоно уу.



- A. Дэлхий дээр олборлосон бүх алтаар 24 метр диаметртэй цул алтан бөмбөг хийж болно.
- B. Дэлхий дээр олборлосон бүх алтаар 24 метр диаметртэй цул алтан бөмбөг хийж болно.
- C. Дэлхий дээр олборлосон бүх алтаар 24 метр диаметртэй цул алтан бөмбөг хийж болно.
- D. Дэлхий дээр олборлосон бүх алтаар 24 метр диаметртэй цул алтан бөмбөг хийж болно.

15. MS Paint программын ажлын хуудасны харагдах байдлыг тохируулах цэсийг сонгоно уу.



- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4

16. MS Paint программ дээр зурсан зургийнхаа тодорхой хэсгийг нарийвчлан харахын тулд аль хэрэгслийг ашиглах вэ?

- A. pencil
- B. magnifier
- C. skew
- D. selection

17. Сурагч MS Paint программ дээр байшин зуржээ. Байшингийн дээврийн өнгийг улаан өнгөөр өөрчлөн будах шаардлагатай болов. Аль хэрэгсэл, командыг ашиглах нь хамгийн тохиромжтой вэ?






- A. Fill with color → Color
- B. Pencil → Eraser → Fill
- C. Color picker → Pencil
- D. Color → Brushes

18. Сурагч MS Paint программ дээр байшингийнхаа хажууд нэг мод зуржээ. Тэрээр уг модыг олшруулж, ойн төгөл болгохын тулд модны хэмжээ болон байршлыг өөрчлөх шаардлагатай болов. Энэ үйлдлийг зөв гүйцэтгэхэд тохирох хэрэгслүүдийн зөв дарааллыг сонгоно уу.



- Select → Copy → Paste → Resize
 - Resize → Select → Copy → Paste
 - Copy → Paste → Resize → Select
 - Select → Resize → Colors → Eraser
19. MS Paint программ дээр дараах зааврын дагуу бүтээсэн зургийг сонгоно уу.
- Line дүрсийг сонгож ажлын талбарыг хэвтээ чиглэлд хоёр хувааж, дээд хэсгийг цэнхэр (тэнгэр), доод хэсгийг шар (элсэн цөл) өнгөөр Fill with color ашиглан будна.
 - Triangle дүрсийг сонгож, тэнгэр болон элсэн цөл хэсгийн оролцуулан өөр өөр хэмжээтэй гурван гурвалжин зурж, улбар шар өнгөөр Fill with color ашиглан будна.
 - Line дүрсийг сонгон зурсан гурвалжингуудыг хувааж, нэг талыг нь шар өнгөөр будна.
 - Тэнгэрийн хэсэгт Oval дүрсийг сонгож дугуй дүрс зурж, шар өнгөөр будна.
 - Line дүрсийг сонгож нарны эргэн тойронд цацраг зурааснуудыг нэмж зурна.
 - Зургийн доод хэсэгт Text хэрэгслийг ашиглан "ПИРАМИД" гэж хар өнгөөр бичнэ.



20. Сурагч “Монгол орны усны хэрэглээ” сэдвээр танилцуулга бэлтгэхийн тулд интернэт ашиглахаар болжээ. Интернэтийн орчинд мэдээлэл хайх хамгийн үр дүнтэй аргыг сонгоно уу.
- Өөрийн байнга ордог, танил веб сайтаас хайлт хийхгүйгээр шууд мэдээлэл авах
 - Хайлтын системээс түлхүүр үг ашиглан, хайлт хийх
 - Хайлтын үр дүнгээс хамгийн эхэнд гарч ирсэн үр дүнг найдвартай гэж үзэж ашиглах
 - Нэг эх сурвалжаас авсан мэдээллийг хангалттай гэж үзэн шууд ашиглах